



МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР  
САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙДЫН  
ТУШААЛ

2024 оны 09 сарын 20 өдөр

Дугаар А/18

Улаанбаатар хот

Жагсаалтад нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулийн 2 дугаар хавсралтын IV.2.4.1, Засгийн газрын 2023 оны 409 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/”-ын жагсаалтад хавсралтад заасан төсөл, арга хэмжээг нэмсүгэй.

2. Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 03 дугаар сарын 29-ний өдрийн А/12 дугаар тушаалын хавсралтаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний техник, эдийн засгийн үндэслэл, зураг төсөв, зөвлөх үйлчилгээний бэлтгэл хангалт /Улсын хэмжээнд/”-ын жагсаалтын 30 дахь хэсгийн “Ханх сум, Цагааннуур сум” гэснийг, Тэргүүн шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайдын 2024 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/08 дугаар тушаалын нэгдүгээр хавсралтын 3, 6 дахь хэсэгт заасан төсөл, арга хэмжээг тус тус хассугай.

3. Хавсралтаар тусгагдсан төсөл, арга хэмжээний жагсаалтыг Төрийн худалдан авах ажиллагааны газарт хүргүүлж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (И.Батхүү)-д даалгасугай.

МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД  
БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН  
САЙД

Л.ГАНТӨМӨР



240101